



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 03 сарын 12 өдөр

Дугаар А/20

Мандалговь

Шилдэг эцэг эхийн зөвлөл
шалгаруулах журам батлах тухай

Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 15.1.5, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5, 18.1.6, Гэр бүлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 28, 29 дүгээр зүйл, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эцэг эхийн зөвлөл”-ийн үйл ажиллагаанд идэвхи санаачлага гарган ажилласан төр, хувийн хэвшлийн аж ахуй нэгж, байгууллагуудыг үнэлж урамшуулах, үйл ажиллагааг олон нийтэд таниулан сурталчилах зорилгоор “Шилдэг эцэг эхийн зөвлөл”-ийг шалгаруулах журмыг хавсралтаар баталсугай.

2. Төрийн байгууллага, аж ахуй нэгжүүд эцэг эхийн зөвлөлийг байгуулж “Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичиг”-ийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг жил бүр баталж, хэрэгжилтийн явц, төлөвлөгөө, тайланг хагас, бүтэн жилээр гарган Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт ирүүлж байхыг хүссүгэй.

3. Журмын хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар ханган, хяналт тавьж, төлөвлөгөө, тайланг нэгтгэн танилцуулж ажиллахыг Гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтан (Б.Бүжинлхамд)-д үүрэг болгосугай.

4. Журам шинэчлэгдсэн баталсантай холбогдуулан газрын даргын 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн А/75 тоот тушаалыг хүчингүй болгосугай.

ДАРГА



Ц.ГАНЗОРИГ

48119004